



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/11/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

Б.Азбаяр

Утас: 99061429

Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/96
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519177

E:\ajil\2019 on\STA 2018\13. Bayanbulag ZDTG\4.Tailagnal\Аудитын гэрчилгээ.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянбулаг сумын ЗДТГ-ын дарга Д.Цэнд-Аюушд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Б. Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.07-ны өдрийн № 07 албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянбулаг сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Төв Азийн өндөрлөг Баянбулаг хайрхандаа шүтэж, онгон байгалиа хадгалан, оюуны чадамж бүхий ахмад үеэсээ суралцан, хүний хөгжлийг хангаж уламжлалт мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлсэн дэд бүтцэд тулгуурлан, зах зээлд өрсөлдөхүйц нутгийн шилдэг бүтээгдэхүүнтэй хангайн бүсийн тэргүүлэх сум болно.

Үйл ажиллагааны чиглэл:

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулиар Баянбулаг сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр эдийн засаг нийгмийн бодлогыг удирдлагын үйл ажиллагаа Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны хурлаар хяналт шалгалтын үр дүнг баталгаажуулж хэлэлцүүлэх.
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт, шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах.

Баянбулаг сумын ЗДТГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянбулаг сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Баянбулаг сумын ЗДТГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянбулаг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянбулаг сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянбулаг сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 2 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон ба аккруэл сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзлээ.

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны Нийт зардал 380503,4 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 7610,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	3.1	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	3.1	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.8.1.1. Ажиллагсадтай холбоотой 3070.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн бөгөөд энэхүү авлагын насжилт ихсэж, эзэн холбогдогч нь ажлаас чөлөөлөгдсөн тул төсөвт буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянбулаг сумын ЗДТГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 301929.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 273926.3 мянган төгрөг буюу 90.7 хувьтай бөгөөд оны эцэст 30005.6 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянбулаг сумын ЗДТГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд мэдээлбэл зохих 25 мэдээнээс хугацаадаа 14 мэдээ, мэдээлээгүй байсныг Шилэн дансны хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16,084,449.03</u>	<u>21,978,434.85</u>
33	АВЛАГА	1,380,261.00	3,079,035.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,130,261.00	3,079,035.32
335	Бусад авлага	250,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	250,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,704,188.03	18,899,399.53
351	Түүхий эд материал	8,140,775.00	8,140,775.00
35110	Тусгай зориулалттай материал	8,140,775.00	8,140,775.00
354	Хангамжийн материал	6,563,413.03	10,758,624.53
35410	Бичиг хэргийн материал	185,000.00	115,200.00
35420	Аж ахуйн материал	818,905.00	2,818,905.00
35470	Бусад хангамжийн материал	5,559,508.03	7,824,519.53
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>472,695,888.42</u>	<u>576,542,359.62</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	472,695,888.42	576,542,359.62
392	Биет хөрөнгө	472,695,888.42	567,436,159.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	399,853,950.00	483,409,608.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-111,451,506.25	-119,500,530.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	119,101,128.00	125,741,128.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-63,926,605.57	-76,457,371.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,705,344.00	179,285,444.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-137,557,124.99	-140,669,690.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,782,391.00	35,782,391.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,285,081.38	-32,042,512.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	117,264,720.00	131,344,720.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,791,326.39	-19,457,026.41
393	Биет бус хөрөнгө	00.00	9,106,200.00
39301	Програм хангамж	230,000.00	230,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-230,000.00	-230,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	9,106,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>488,780,337.45</u>	<u>598,520,794.47</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>659,226.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	659,226.00	00.00
413	Өглөг	659,226.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>488,121,111.45</u>	<u>598,520,794.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	488,121,111.45	598,520,794.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	293,021,837.00	302,128,037.00
51101	Өмч: - төрийн	293,021,837.00	302,128,037.00
512	Хуримтлагдсан үр дүн	194,953,104.45	278,906,861.51
51210	Өмнөх үеийн үр дүн	194,953,104.45	194,953,104.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	83,953,757.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	146,170.00	17,485,895.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>488,780,337.45</u>	<u>598,520,794.47</u>

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	325,105,554.27	464,457,131.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,370,905.00	137,339,911.50
120	Нийтлэг татварын бус орлого	8,370,905.00	137,339,911.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,370,905.00	137,339,911.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,370,905.00	137,139,911.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	316,734,649.27	327,117,220.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,975,944.00	23,175,288.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,975,944.00	23,175,288.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	282,389,585.27	298,461,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	282,389,585.27	298,461,800.00
1330	Төсвийн захирагчдаас	23,369,120.00	5,480,132.00
133003	Хөрөнгийн	23,369,120.00	5,480,132.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	317,448,206.10	349,365,111.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	317,448,206.10	349,365,111.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	292,213,314.83	316,866,560.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,916,893.00	153,987,433.68
210101	Үндсэн цалин	162,017,093.00	153,404,153.68
210105	Гэрээт ажлын хөлс	16,899,800.00	583,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,046,400.00	41,393,416.00
210201	Тэтгэврийн даатгал	20,046,400.00	37,171,656.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	953,210.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	841,120.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	219,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,207,630.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,265,751.00	19,432,897.00
210301	Гэрэл, цахилгаан	2,587,251.00	1,864,097.00
210302	Түлш, халаалт	18,678,500.00	17,568,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,145,910.00	26,111,173.00
210401	Бичиг хэрэг	3,968,700.00	3,639,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,398,560.00	18,262,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,096,200.00	1,535,600.00
210404	Ном, хэвлэл	1,648,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,033,950.00	2,196,120.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	477,503.00
2105	Нормативт зардал	800,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,257,200.00	923,800.00
210604	Урсгал засвар	2,257,200.00	923,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,819,670.00	5,307,550.00
210702	Дотоод албан томилолт	5,819,670.00	5,307,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,355,814.00	20,042,117.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,278,014.00	17,594,317.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	00.00

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,800.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,447,800.00
210807	Газрын төлбөр	90,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,605,676.83	49,668,173.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,983,000.00	5,786,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,372,676.83	43,881,223.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,234,891.27	32,498,551.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,068,364.00	2,493,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,518,364.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,550,000.00	2,493,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	984,327.27	30,005,551.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	984,327.27	30,005,551.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,182,200.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,182,200.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>7,657,348.17</u>	<u>115,092,020.30</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	31,138,263.24
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	31,138,263.24
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-31,138,263.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>7,657,348.17</u>	<u>83,953,757.06</u>

Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>293,365,529.27</u>	<u>321,837,088.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>293,365,529.27</u>	<u>321,637,088.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,975,944.00	23,175,288.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,975,944.00	23,175,288.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	282,389,585.27	298,461,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	282,389,585.27	298,461,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>293,365,529.27</u>	<u>321,837,088.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>293,365,529.27</u>	<u>321,837,088.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>268,130,638.00</u>	<u>279,538,537.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,421,893.00	176,046,049.00
210101	Үндсэн цалин	161,522,093.00	164,631,876.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,899,800.00	11,414,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,046,400.00	21,621,601.00
210201	Тэтгэврийн даатгал	19,930,900.00	16,286,801.00

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	115,500.00	1,290,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,138,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	264,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,641,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,538,601.00	20,912,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,860,101.00	2,894,400.00
210302	Түлш, халаалт	18,678,500.00	18,018,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,815,930.00	16,908,400.00
210401	Бичиг хэрэг	3,415,300.00	2,820,400.00
210402	Тээвэр, шатахуун	16,190,430.00	12,102,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,434,200.00	1,859,000.00
210404	Ном, хэвлэл	1,560,500.00	20,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,215,500.00	106,600.00
2105	Нормативт зардал	200,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,357,200.00	4,926,000.00
210602	Тавилга	4,100,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	2,257,200.00	926,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,785,800.00	5,425,700.00
210702	Дотоод албан томилолт	5,785,800.00	5,425,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,355,814.00	25,499,387.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,278,014.00	22,895,387.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,800.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,604,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,609,000.00	8,199,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	8,099,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	609,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4333054.54	79611102.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	9,800,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	9,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,166,527.27	39,805,551.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,518,364.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,550,000.00	2,493,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	984,327.27	30,005,551.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	984,327.27	30,005,551.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,182,200.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,182,200.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	293,021,837.00	146,170.00	194,953,104.45	00.00	488,121,111.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	293,021,837.00	146,170.00	194,953,104.45	00.00	488,121,111.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	17,339,725.96	00.00	00.00	17,339,725.96
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	9,106,200.00	00.00	83,953,757.06	00.00	93,059,957.06
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	302,128,037.00	17,485,895.96	278,906,861.51	00.00	598,520,794.47

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	282,197,400.00	281,405,258.00	301,929,400.00	273,926,337.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	282,197,400.00	281,405,258.00	301,929,400.00	273,926,337.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	259,102,200.00	258,336,894.00	269,089,000.00	261,633,337.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,689,300.00	176,381,393.00	182,055,300.00	176,046,049.00
210101	Үндсэн цалин	159,789,500.00	159,481,593.00	168,439,400.00	164,631,876.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,899,800.00	16,899,800.00	13,615,900.00	11,414,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,150,800.00	19,930,900.00	22,050,000.00	21,621,601.00
210201	Тэтгэврийн даатгал	20,150,800.00	19,930,900.00	14,914,300.00	16,286,801.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	1,783,900.00	1,290,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	1,427,100.00	1,138,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	356,800.00	264,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	3,567,900.00	2,641,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,722,900.00	21,538,601.00	20,912,400.00	20,912,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,044,400.00	2,860,101.00	2,894,400.00	2,894,400.00
210302	Түлш, халаалт	18,678,500.00	18,678,500.00	18,018,000.00	18,018,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,252,000.00	19,296,200.00	16,908,400.00	16,908,400.00
210401	Бичиг хэрэг	3,148,500.00	3,415,300.00	2,820,400.00	2,820,400.00
210402	Тээвэр, шатахуун	11,777,500.00	11,670,700.00	12,102,400.00	12,102,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,550,000.00	1,434,200.00	1,859,000.00	1,859,000.00
210404	Ном, хэвлэл	1,560,500.00	1,560,500.00	20,000.00	20,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,215,500.00	1,215,500.00	106,600.00	106,600.00
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	00.00	00.00

Баянбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,457,200.00	6,357,200.00	5,926,000.00	4,926,000.00
210602	Тавилга	4,200,000.00	4,100,000.00	5,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	2,257,200.00	2,257,200.00	926,000.00	926,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,768,200.00	5,785,800.00	5,425,700.00	5,425,700.00
210702	Дотоод албан томилолт	5,768,200.00	5,785,800.00	5,425,700.00	5,425,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,237,800.00	3,237,800.00	7,612,200.00	7,594,187.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,160,000.00	2,160,000.00	4,990,200.00	4,990,187.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	600,000.00	00.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,800.00	117,800.00	18,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00	00.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	2,604,000.00	2,604,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	90,000.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5624000.00	5609000.00	8199000.00	8199000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	8,099,000.00	8,099,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	624,000.00	609,000.00	100,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23095200.00	23068364.00	32840400.00	12293000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	29,147,400.00	9,800,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	29,147,400.00	9,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,095,200.00	23,068,364.00	3,693,000.00	2,493,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,545,200.00	15,518,364.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,550,000.00	7,550,000.00	3,693,000.00	2,493,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	282,197,400.00	281,405,258.00	299,861,800.00	273,926,337.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	282,197,400.00	280,805,258.00	299,261,800.00	273,726,337.00
132001	Орон нутгийн төсвөөс	282,197,400.00	280,805,258.00	299,261,800.00	273,726,337.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	600,000.00	600,000.00	200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	600,000.00	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	600,000.00	200,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00	28.00	28.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	21.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	04.00	04.00